



Ард Санхүүгийн Нэгдэл

Хагас жилийн тайлан

Эрхэм зорилго

Ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэржүүлэн барьснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн дээд түвшинд барих бодлогыг мөрдөнө.

Алсын хараа

Бүс нутагтаа хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүний технологитой санхүүгийн нэгдэл компани болно.

Ард Санхүүгийн Нэгдэл энэ улиралд ахин гайхалтай өсөлт үзүүлэн ажилласныг дуулгахад таатай байна. Бид өөрсдийн түүхэн дэх дээд амжилтыг эвдэж, Холдинг компанийн ашиг энэ улиралд 8 тэрбумд хүрлээ. Ард Кредитын харилцагчийн тоо 130,000-д хүрч, сүүлийн гурван сард нийт хөрөнгийн хэмжээ 2 дахин өслөө. Мөн Ард Кредит болон Ард Даатгалын хувьд ч хамгийн ашигтай ажилласан улирал болж байна.


Үүнээс гадна АрдКойн томоохон амжилтыг үзүүлж, 5, 6 сард олон нийтийн анхаарлын төвд байж үнэ нь 5 дахин өсөж 5 төгрөгт хүрч тогтворжив.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос манай урвуу нэгдлийг зөвшөөрсөн бөгөөд Монголын Хөрөнгийн Биржтэй тохиролцсоны үр дүнд Альфа Ард буюу AARD тикертэйгээр арилжааг эхлүүлэхээр боллоо.


Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооноос олон нийтийн сан байгуулах Ард Менежментийн хүсэлтийг зөвшөөрсөн хариу гарлаа. Энэ нь манай улсад олон нийтийн сан байгуулах анхны лиценз бөгөөд энэ оны хоёрдугаар хагаст Үндэсний Хувьчлалын Санд хөрөнгө төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Хүндэтгэсэн,
Хутагт овогт Чулууны Ганхуяг
Ард Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирал

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Урвуу нэгдлийн дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Төлөөлөн Удирдах Зөвлөл



ТУЗ-ийн дарга,
Ард Санхүүгийн Нэгдэл
Пүрэвжаргал **Батбаяр**



Гүйцэтгэх захирал,
Ард Санхүүгийн Нэгдэл
Чулуун **Ганхуяг**



Дэд ерөнхийлөгч,
Шродер Адвек
Бруно **Рашле**



Гүйцэтгэх захирал,
Хишиг Арвин Индустриал
Хишигдорж **Батхишиг**



Ерөнхийлөгч,
Саут Гоби Сэндс
Чулуун **Мөнхбат**



Үүсгэн байгуулагч,
ГрэйпСити Монгол
Авир **Сүхдорж**



Ерөнхийлөгч,
ТТДС
Мөнх-Очир **Сэргэлэн**



Гүйцэтгэх захирал,
Мон-Интернэйшнл
Одончимэд **Одбаяр**



ТУЗ-ийн дарга,
Азийн Кредитын сан
Жим Андерсон



Хяналтын зөвлөлийн дарга,
Грийн Лийф Капитал
Михайл Зелдович

Хөрөнгө оруулалтын багц

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ



Үйл ажиллагааны тайлан

Ард Санхүүгийн Нэгдэл нээлттэй хувьцаат компани боллоо

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 5 сарын 8-ны өдрийн хурлаар Жинст Увс, Ард Санхүүгийн Нэгдэл компаниудын урвуу нэгдлийн асуудлыг хэлэлцэж, зөвшөөрсөн байна. Ингэснээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа Монголын Хөрөнгийн Бирж дээр Альфа Ард буюу MSE: AARD тикерээр арилжаалагдаж эхэлнэ.



MSE:  AARD

Хөрөнгө Оруулагч Үндэстэн форум ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ



Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг идэвхжүүлж ард иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилго бүхий Хөрөнгө Оруулагч Үндэстэн Форум 3 дахь жилдээ зохион байгуулагдаж, 1,000 орчим оролцогч оролцлоо.

Тус арга хэмжээний хүрээнд олон улсын хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн сүүлийн үеийн мэдээ мэдээлэл, хөгжлийн чиг хандлага, шинэ санаачлагуудыг танилцуулахын сацуу, тухайн салбарын мэргэжилтэн, экспертүүдийн илтгэл, хэлэлцүүлэг мөн явагдсан юм.

Ард Кредитын IPO



Ард Кредитын анхдагч зах зээлийн хувьцааны захиалга 2 сарын 18-аас 3 сарын 1-ний хооронд явагдаж, компанийн 25 хувь буюу 70,000,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч болон олон нийтэд санал болгосон билээ.

Стратегийн хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөг босгосон бол олон нийтэд санал болгосон хэсэгт нийт 1,763 хувь хүн, аж ахуй нэгжээс 7.3 тэрбум төгрөгийн захиалга ирж, татан төвлөрүүлэх доод дүнгээс даруй 299 хувь давж биелэв.

Ард Шоп



Ард Шоп нь iOS болон Android үйлдлийн системд зориулсан Апп-аа гаргалаа. Мөн БНХАУ-ын хоёр дахь том онлайн дэлгүүр IntMall болон Монгол Шуудантай хамтран Хятадаас шууд захиалга хийх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр 800 мянга гаруй бараа бүтээгдэхүүнийг нэмэлт төлбөр төлөхгүйгээр захиалах боломжтой болох юм.

Ард Койн



Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай Ард Бит компани криптовалют болон блокчэйн технологийн салбарт тэргүүлэгч ICT Group-тэй хамтарч монголын анхны крипто токен АрдКойн (etherscan.io:ARDX)-ыг гаргалаа.

Уг токен нь блокчэйн технологид суурилсан бөгөөд одоогийн байдлаар trade.mn арилжаалагдаж байгаа юм. Одоогоор Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай компаниудын харилцагчдын урамшууллын лоялти оноогоор ашиглагдаж байна.

Сугалаат аян

Бид оны эхэнд буюу 1 сарын 19-нд Ард Алп-ыг сурталчлах, хэрэглэгчдийг татах, Ард Шопд хандах хэрэглэгчийн урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор автомашины хонжвортой сугалаат аяныг эхлүүлсэн билээ. Эхний сугалаат аяны азтанаар М.Отгонбаатар тодорч, 2 дахь сугалаат аяны азтанаар Д.Сарантуяа тодорлоо.



I улирлын сугалаат аян

Оролцсон харилцагч

10,000

Борлуулагдсан сугалаа

180,000



II улирлын сугалаат аян

Оролцсон харилцагч

12,000

Борлуулагдсан сугалаа

290,000

Хувьцаатай хүүхэд

Хүүхдийн баярыг тохиолдуулан Хувьцаатай хүүхэд аяныг дахин зарлалаа. 2018 оны 7 сараас хэрэгжүүлж эхэлсэн энэ аянд нийт 462 хүүхэд нэгдэж урт хугацааны хөрөнгө оруулалт хийсэн байна.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит, Жинст Увс (Хөрөнгө Оруулагч Үндэстэн) компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 сарын 27-ны өдөр 2,000 гаруй хувьцаа эзэмшигчид Зайсан Хилл комплексийн хурлын танхимд хүрэлцэн ирснээр амжилттай болж өнгөрлөө.

Хурлын ирцийн мэдээлэл



Крауд Кредит Сангийн санхүүжилт

Ард Кредит нь өнгөрсөн 2 дугаар сард Япон улсын Крауд Кредит Сан-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурснаар нийт 5 сая доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр болов.



Тайлант хугацааны эцэст нийт **1.6** тэрбум төгрөг санхүүжилтийн Крауд Кредит Сан олгосон байна.

Ард Апп

Нийт хэрэглэгчдийн тоо **139,600** боллоо.

Fast Cash - Онлайн зээлийн үйлчилгээ

Олгосон зээлийн тоо **33,005**


Нийт олгосон зээлийн дүн **12.9** тэрбум төгрөг

Дундаж зээлийн дүн **414,000** төгрөг

Эргэн төлөгдсөн зээлийн тоо **39,119**

Эргэн төлөгдсөн дүн **4.59** тэрбум төгрөг

Хугацаа хэтрэлт **2.9** хувь



ZERO mn



Онлайн тасалбар захиалгын платформ болох Zero.mn-ийг Ард Апп-тай амжилттай холбосноор манай харилцагчид аль ч кино театрын тасалбарыг шууд худалдан авах боломжтой болов.

TRADE DIGITAL EXCHANGE

Мөн Ард Апп-ыг Trade.mn-тэй нэгтгэснээр АрдКойныг бидний үндсэн систем болон Trade.mn-ий хооронд шилжүүлэх боломжтой болов.

Ард Апп зээл авахад

 **ХЯЛБАР
ШУУРХАЙ**



Санхүүгийн тайлан

Нийт хөрөнгө 73.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 12.6 тэрбум төгрөгөөр буюу 21 хувиар өсжээ. Энэ өсөлтөд Ард Кредитын IPO голлох нөлөөг үзүүлж, бидний эзэмшлийн хувийн үнэлгээ 10 тэрбум төгрөгөөр өссөн юм.

Нийт өр төлбөр 9.9 тэрбум төгрөгөөс 14.4 тэрбум төгрөг болж, 4.6 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс урт хугацаат өр төлбөр оны эхний хагаст 2.5 тэрбум төгрөгөөр өсөж 8.2 тэрбум төгрөг болсон байна.

Мөн хөрөнгө оруулалтын багцын өсөлттэй холбоотойгоор хойшлогдсон татварын өр 1.1 тэрбум төгрөгөөс өсөж, 3.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Эздийн өмч 8.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэлгээ 58.6 тэрбум төгрөг болов.



Санхүүгийн үзүүлэлт

НИЙТ ҮНЭЛГЭЭ



НЭГЖ ХУВЬЦААНЫ ҮНЭЛГЭЭ



НИЙТ ХӨРӨНГӨ



ӨР ТӨЛБӨР



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ



ӨСӨЛТИЙН ХУВЬ

Хагас жилээр

16%

Бүтэн жилээр

29%

Хагас жилээр

16%

Бүтэн жилээр

29%

Хагас жилээр

21%

Бүтэн жилээр

41%

Хагас жилээр

45%

Бүтэн жилээр

143%

Хагас жилээр

16%

Бүтэн жилээр

27%

Санхүүгийн байдлын хураангуй тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ

(сая төгрөг)	Санхүү	2018 II	2018 IV	2019 II	YTD	YoY
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		2,858	2,035	702,057	34,399%	24,465%
Авлага болон УТТ		1,657,502	3,519,133	6,692,962	90%	304%
Бусдад олгосон зээл		7,224,542	7,184,324	5,337,937	-26%	-26%
Үндсэн хөрөнгө	100%	785,775	986,546	908,255	-8%	16%
БЗҮХХөрөнгө		1,220,000	4,817,832	5,001,656	4%	310%
Богино хугацаат хөрөнгө оруулалт		48,063	146,055	398,213	173%	729%
Урт хугацаат хөрөнгө оруулалт		40,928,492	43,810,719	53,836,872	23%	32%
Нийт хөрөнгө	80.03%	51,867,232	60,466,644	72,877,952	21%	41%
Богино хугацаат өр төлбөр		1,596,583	2,233,933	3,226,585	44%	102%
Урт хугацаат өр төлбөр		2,779,433	5,765,041	8,195,528	42%	195%
Хойшлогдсон татварын өглөг		1,573,682	1,957,038	3,035,441	55%	93%
Нийт өр төлбөр		5,949,698	9,956,012	14,457,554	45%	143%
Энгийн хувьцаа		1,719,436	1,719,436	1,719,436	0%	0%
Нэмж төлөгдсөн капитал		9,929,061	9,929,061	9,929,061	0%	0%
Бодит үнэ цэнийн өсөлт		9,997,487	14,081,066	23,786,701	69%	138%
Бусад		13,799	13,799	13,799	0%	0%
Хуримтлагдсан ашиг		24,257,751	24,767,270	22,971,401	-7%	-5%
Хувьцаа эзэмшигчдийн өмч		45,917,534	50,510,632	58,420,398	16%	27%
Нийт эх үүсвэр		51,867,232	60,466,644	72,877,952	21%	41%

Орлого үр дүнгийн хураангуй тайлан

(сая төгрөг)

	2018 II	2018 IV	2019 II	YTD	YoY
Хөрөнгө оруулалтын болон ногдол ашгийн орлого	2,131,065	3,740,312	622,810	-83%	-71%
Бусад орлого	673,649	1,390,719	678,165	-51%	1%
Нийт орлого	2,804,714	5,131,031	1,300,975	-75%	-54%
Удирдлагын болон ҮА-ны зардал	1,606,927	3,627,107	2,774,372	-24%	73%
Санхүүгийн зардал	325,557	863,114	553,572	-36%	70%
Нийт зардал	1,932,484	4,490,221	3,327,944	-26%	72%
Бусад ашиг (алдагдал)	-63,439	97,098	246,410	154%	-488%
Ханшийн зөрүүгийн ашиг (алдагдал)	11,886	54,644	-550	-101%	-105%
Татварын өмнөх ашиг	820,677	792,552	-1,781,109	-325%	-317%
Татвар	108,409	124,919	14,759	-88%	-86%
Цэвэр ашиг	712,268	667,633	-1,795,868	-369%	-352%
Дахин үнэлгээний олз (цэвэр)	1,906,374	6,730,845	9,705,635	44%	409%
Нийт ашиг	2,618,642	7,398,478	7,909,767	7%	202%

Үнэлгээний хураангуй тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЦ

Салгуу	Хөрөнгө			Дэд бүтэц	
(сая төгрөг)	2018 II	2018 IV	2019 II	YTD	YoY
Стратегийн хөрөнгө оруулалт	35,748,152	40,330,724	49,876,877	24%	40%
Монгол Шуудан (MNP)	16,306,643	16,334,008	17,057,788	4%	5%
ХОУ (JIV)	14,216	23,410	23,112	-1%	63%
Ард Даатгал (AIC)	9,527,682	12,927,759	12,844,913	-1%	35%
Ард Кредит (ADB)	4,557,999	5,028,012	13,922,530	177%	205%
Ард Секюритиз	2,126,211	2,304,926	2,304,926	0%	8%
Ард Лайф	2,362,060	2,426,041	2,426,041	0%	3%
Ард Менежмент	365,333	365,333	365,333	0%	0%
Ард Актив	14,501	47,726	58,726	23%	305%
Ард Бит (GoPay орсон)	200,000	200,000	200,000	0%	0%
ТэнГэр Системс (Trade.mn орсон)	273,508	673,508	673,508	0%	146%
Бусад	853,342	1,286,567	1,297,567	1%	52%
Стратегийн бус хөрөнгө оруулалт	5,067,233	3,479,995	3,479,995	0%	-31%
Бусад	6,562,724	8,657,000	7,618,967	-12%	16%
Нийт үнэлгээ	47,378,109	52,467,719	60,975,839	16%	29%
Гүйлгээнд байгаа хувьцааны тоо	17,194,364	17,194,364	17,194,364	0%	0%
Нэгж хувьцааны үнэлгээ (ARD)	2,755	3,051	3,546	16%	29%
Нэгж хувьцааны үнэлгээ (JIV)	1,758	1,947	2,263		

Охин компаниудын арилжааны статистик

Компани	Тикер	Арилжаалагдсан өдөр	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт (QoQ)	Өдрийн дундаж арилжааны дүн
Ард Кредит	ADB	65	81	83	65	81.83	1.02%	12,418,243
Ард Даатгал	AIC	61	685	770	599	769.35	12.31%	14,200,462
Монгол Шуудан	MNP	43	600	700	521	691.16	15.19%	5,538,348
Жинст Увс	JIV	29	1900	2,100	1,720	1,911	0.58%	3,138,852



Урвуу нэгдэх үйл явц



Хөрөнгө Оруулагч Үндэстэн
компанийг байгуулав

Жинст Увс (ХОУ) болон
Ард Санхүүгийн Нэгдэл
нэгдэх зөвшөөрөл гарав

2015

2016

2017

2018

2019

Жинст Увс ХК-ийг
худалдан авав

Хөрөнгө Оруулагч Үндэстэн,
Жинст Увс руу урвуу нэгдэж
МХБ дээр бүртгэгдэв

Ард Санхүүгийн Нэгдэл
Жинст Увс руу урвуу нэгдэж
МХБ дээр бүртгэгдэв



Урвуу нэгдлийн тооцоолол

Хөрвөх харьцаа

$$\frac{\text{Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны үнэлгээ}}{\text{Жинст Увсын хувьцааны үнэлгээ}} = \frac{2,912}{1,858} = 1.567$$

Нэгдэхээс
өмнө

Нийт гаргасан хувьцаа

Жинст Увс

1,665,938

+

26,948,325

Ард

17,194,364

Нэмж гаргах хувьцаа

Нэгдсэний
дараа

Нийт гаргасан хувьцаа

28,614,263

Халаасны хувьцаа

1,797,252

Жинст Увс

149,026

+

1,648,226

Ард

1,051,650

Хэрвээ та Ард Санхүүгийн Нэгдлийн 1,000 ширхэг хувьцаатай бол 1.567 харьцаагаар хөрвөөд 1,567 ширхэг хувьцаатай болох юм. Ингэснээр хувьцааны тоо болон нэгжийн үнэ өөрчлөгдөж байгаа ч нийт дүн өөрчлөгдөхгүй. Харин Жинст Увсын хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо болон үнэд өөрчлөлт орохгүй.

Нэгдэхээс өмнө

1,000 ширхэг

1.567x

Нэгдсэний дараа

1,567 ширхэг



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА



MSE: ARD